



ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРААР ҮЙЛЧЛҮҮЛЖ БУЙ ИРГЭДЭЭС 2025 ОНЫ 11 САРД АВСАН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ НЭГТГЭЛ

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО: Энэхүү судалгаа нь Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын үйлчилгээг сайжруулах, иргэдийн сэтгэл ханамжийн дээшлүүлэхэд оршино.

СЭТГЭЛ ХАНАМЖ: Сэтгэл ханамж гэдэг нь хэрэглэгч /нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэд/ Нийгмийн даатгалын үйлчилгээнээс гарч буй чанарын түвшин буюу тухайн үйлчилгээг хэрхэн үнэлж байгааг илтгэдэг бөгөөд үр дүн нь тоон хэмжүүрт тулгуурласан байдаг.

АЧ ХОЛБОГДОЛ: Хэрэглэгчийн тухайн Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээнээс буй хүлээлт хүссэн үйлчилгээг нь үр дүнтэй болгох.

СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ: Санал асуулгын түүвэр судалгааны аргыг ашиглан SPSS программ дээр шинжилнэ.

СУДАЛГААНЫ БАРИМТЛАХ ЗАРЧИМ


- Судалгааны үр дүн нь ач холбогдолтой, үйл ажиллагаанд шууд авч ашиглах боломжтой байх.
- Хөндлөнгийн хараат бус байх
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн аргачлал арга зүйг судалгааны бүхий л үе шатанд дагаж мөрдөх

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ: Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын Нэг цэгийн үйлчилгээний тасагт иргэдээс нээлттэй байдлаар санал асуулга авсан.



СУДАЛГААНЫ АСУУЛГУУД

Асуумж1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн насны ангилал:



Дүгнэлт: Судалгаанд оролцсон нийт 107 иргэдийн насны хувьд авч үзвэл 25 хүртэлх насны 13 иргэн буюу 12.1%, 25-34 насны 10 иргэн буюу 9.3% , 35-44 насны 40 иргэн буюу 37.4%, 45-54 насны 19 иргэн буюу 17.8% , 55-с дээш насны 24 иргэн буюу 22.4% тус бүрийн тоон үзүүлэлтүүд гарсан байна.

Асуумж2:Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн хүйс:






Дүгнэлт: Орхон аймгийн Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлэхээр ирсэн иргэдээс 11 сард авсан судалгаанд 107 иргэн хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан иргэдийг хүйсээр авч үзвэл 60 иргэн буюу 57% эмэгтэй, 47 иргэн буюу 43% нь эрэгтэй гэсэн тоон үзүүлэлт гарч байна.

Асуумж3: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн боловсролын байдал:

Боловсролын байдал



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 107 иргэдийн боловсролын байдлыг үнэлэхэд бага боловсролтой 4 иргэн буюу 3.7%, бүрэн дунд боловсролтой 61 иргэн дийлэнх хувийг буюу 57%, дээд боловсролтой 41 иргэн буюу 38.3%-ийг тус бүр эзэлж байна.

Асуумж4: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн авч буй үйлчилгээний төрөл:

Үйлчилгээний төрөл



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээ авсан төрлийг үнэлэхэд бусад үйлчилгээг 7 иргэн буюу 6.5%, лавлагаа авсан 8 иргэн буюу 7.5%, сайн дурын




даатгалын гэрээ байгуулсан, төлөлт хийсэн 24 иргэн буюу 22.4%, шимтгэл төлөлтийн тайлан өгсөн 2 иргэн буюу 1.9%, тэтгэвэр тогтоолгох материал өгсөн 31 иргэн буюу 29%, тэтгэмж тогтоолгох материал өгсөн 34 иргэн буюу 31.8% нь тус тус үйлчилгээ авсан байна.

Асуумж5: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн байгууллагын албан хаагчаас мэдээллээ бүрэн авсан байдал:



Дүгнэлт: Судалгаанд оролцсон нийт 107 иргэнээс “Хангалттай” гэсэн үнэлгээг 100 иргэн буюу 93.5% “Дунд зэрэг” үнэлгээг 7 иргэн буюу 6.5% тус тус үнэлсэн байна.


Асуумж6:Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн албан хаагчаас мэдээллээ бүрэн авч чадаагүй талаарх үнэлгээ?



Дүгнэлт: Судалгаанд оролцсон нийт 107 иргэдээс 7 иргэн албан хаагчаас мэдээллээ дунд зэрэг авсан гэж үнэлсэн байна. Үүнээс 1 иргэн буюу 0.9%-н албан хаагчийн мэдлэг муугаас, 1 иргэн буюу 0,9%-н сүлжээ, программ ажиллаагүйгээс, 3 иргэн буюу 2.8%-н их ачаалалттай байснаас гэж тус бүр үнэлсэн байна.



Асуумж7:Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн албан хаагчтай хэдэн удаа уулзсан талаарх үнэлгээ?




Дүгнэлт: Судалгаанд оролцсон нийт 107 иргэдийн үйлчилгээ авахдаа албан хаагчтай 1 удаа уулзсан 89 иргэн буюу 83.2%, 2 удаа уулзсан 15 иргэн буюу 14%, 4 удаа уулзсан 2 иргэн буюу 1.9%, гэж тус бүр хариулсан байна.

Асуумж8: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн албан хаагчтай 3-аас дээш удаа уулзсан шалтгаан?



Дүгнэлт: Судалгаанд оролцсон нийт 107 иргэдээс 2 иргэн албан хаагчтай 3-аас дээш удаа уулзсан байна. Үүнээс “Би өөрөө бичиг баримтаа дутуу бүрдүүлсэн” шалтгаанаар 2 иргэн буюу 1.9%-н байна.


Асуумж9: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн албан хаагчдын харилцааны соёлын үнэлгээ?



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэд, даатгуулагчаас албан хаагчийн харилцааны соёлын үнэлгээ авахад “Хангалттай сайн” үнэлгээг 102 иргэн буюу 95.3%, “Сайжруулах шаардлагатай” үнэлгээг 5 иргэн буюу 4.7%-тай тус бүр үнэлсэн байна.




Асуумж10: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн байгууллагын орчин, тав тухтай байдлыг үнэлсэн үнэлгээ:



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэд, даатгуулагчаас байгууллагын орчин, тав тухтай байдлын үнэлгээ авахад “Хангалттай” гэж 90 иргэн буюу 84.1%, “Сайжруулах шаардлагатай” гэж 17 иргэн буюу 15.9%-тай тус бүр үнэлсэн байна.


Асуумж11: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн байгууллагын орчин, тав тухтай байдлын юуг сайжруулах шаардлагатай гэж үзэж байгааг үнэлсэн үнэлгээ:



Дүгнэлт: Судалгаанд оролцсон нийт 107 иргэдээс 17 иргэн орчин, тав тухтай байдлыг сайжруулах шаардлагатай гэж үзсэн ба үүнээс 15 иргэн яагаад сайжруулах шаардлагатай талаар судалгаанд хамрагдсанаас танхимын зохион байгуулалтыг өөрчлөх 7 иргэн буюу 6.5%, мэдээлэл хангалттай байршуулах 4 иргэн буюу 3.7%, гэрэлтүүлэг хангалттай биш 2 иргэн буюу 1.9%, бусад 2 иргэн буюу 1.9% тус бүр үнэлсэн байна.




Асуумж12: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн нийгмийн даатгалын сурталчилгаа, мэдээллийг авдаг төрөл:



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдээс нийгмийн даатгалын талаарх сурталчилгаа, мэдээллийг хаанаас авдаг талаарх судалгаа авахад вэб хуудаснаас 18 иргэн буюу 16.8%, лавлах утаснаас 1 иргэн буюу 0.9%, байгууллага дээр биеэр ирж 7 иргэн буюу 6.5%, нийгмийн сүлжээгээр 62 иргэн 57.9%, огт авдаггүй 1 иргэн 0.9%, тараах материал, танилцуулгаас 2 иргэн буюу 1.8%, телевизээс 15 иргэн буюу 14% тус бүр мэдээллээ авдаг байна.


Асуумж13: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн нийгмийн даатгалын гар утасны аппликейшныг ашигладаг байдлын үнэлгээ:



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэд, даатгуулагчаас нийгмийн даатгалын гар утасны аппликейшныг ашигладаг талаарх судалгаа авахад 15 иргэн буюу 14% нь татаж авч чадаагүй, 14 иргэн буюу 13.1% нь тийм, 2 иргэн буюу 1.9% нь ухаалаг утас ашиглах боломжгүй, 75 иргэн буюу 70.1% нь үгүй гэж хариулсан байна.



Асуумж14: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн нийгмийн даатгалын www.ndaatgal.mn вэб сайтын талаар мэдээлэл авч байсан байдлын үнэлгээ:



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдээс нийгмийн даатгалын www.ndaatgal.mn вэб сайтын талаар мэдээлэл авч байсан талаарх судалгаа авахад 32 иргэн буюу 29.9% нь мэдэхгүй, 62 иргэн буюу 57.9% нь тийм, 12 иргэн буюу 11.2% нь хааяа гэж тус бүр үнэлсэн байна.

🔔 Судалгаанд оролцсон иргэд санал, хүсэлт өгөөгүй байна.

СУДАЛГААНЫ НЭГТГЭЛ ХИЙСЭН:

НИЙГМИЙН ДААТГАЛЫН АХЛАХ ТӨЛӨӨЛӨГЧ: Н.ШҮРЭН-ЭРДЭНЭ